



МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2014 оны 09 сарын 02 өдөр


Дугаар 22

Улаанбаатар хот

Сонгуулийн Ерөнхий Хорооны албан
хаагчдын ёс зүйн дүрэм батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгуулийн Ерөнхий Хорооны албан хаагчдын ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Энэ захирамжийг мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга /Д.Баяндуурэн/, Мэдээллийн технологийн төвийн захирал /Ж.Эрдэнэбат/ даалгасугай.
3. Энэхүү захирамжийн хавсралтаар батлагдсан дүрмийг 2014 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын
2014 оны 09 дугаар сарын 22.-ны өдрийн
22.. дугаар захирамжийн хавсралт

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ №А0306
АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн Ерөнхий Хорооны албан хаагчид /цаашид “албан хаагчид” гэх/ нь байгууллагын зорилго, үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлж, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргээ биелүүлэхэд баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож, мөрдүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Энэхүү дүрэм нь албан хаагчийг тухайн ажлын байранд хариуцсан ажил, үүргээ чанд биелүүлэх, аливаа хэрэг, зөрчлөөс сэргийлэх, иргэд, байгууллага болон хамт ажиллагадтайгаа зөв боловсон харилцах, албаны болон албан хаагчийн нэр төрийг эрхэмлэж, албандаа хүндэтгэлтэй хандах харилцааг зохицуулна.

Хоёр. Албан хаагчийн баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ

2.1. Албан хаагч нь төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаас гадна үйл ажиллагаанд даацах зарчмыг баримталж ажиллана:

2.1.1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохгүй байх;

2.1.2. Бусдын өмнө үүрэг хүлээх, албан ажлын давуу тал, боломжийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

2.1.3. Албан тушаалын байдлаа ашиглан шийдвэр гаргах болон боловсруулах явцад аливаа хэлбэрээр хөнлөнгөөс нөлөөлөхгүй байх;

2.1.4. Албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, аливаа ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байдлаас татгалзах;

2.1.5. Үйл ажиллагаанд даацааны догонд гол гаргахгүй байхыг эрхэмлэх.

2.2. Албан хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүрэг болон Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасанаас гадна даацах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

2.2.1. Санал, гомдол болон маргаантай асуудлаар хандсан иргэд, байгууллагатай хүндэтгэлтэй, зөв боловсон харилцах;

2.2.2. Өөрийн ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг холбогдох албан тушаалтанд шуурхай танилцуулж байх;

2.2.3. Албан тушаалын байдлаа ашиглан бусдад аливаа хууль бус шаардлага тавихгүй байх, өөртөө буюу бусдад ашиг хонжоо олгох үйлдэл хийлгэхээр шахалт үзүүлэхгүй байх;

2.2.4. Ажлын шугамаар олж авсан мэдээллийг өөр зорилгоор ашиглан иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох аливаа үйлдэл хийхгүй байх, тэднээс бэлэг сэлт, шан харамж, хандив, тусламж зэргийг авахгүй байх;

2.2.5. Албан тушаалын бүрэн эрхэд хамаарах асуудлаар аливаа асуудлыг шийдвэрлэхэд хувь хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн төлөөлөгчидтэй хувийн харилцаа холбоо /төрөл садан, найз нөхөд гэх мэт/-той байдал нь ашиг сонирхолын зөрчил үүсгэж байгаа бол өөрөө оролцоогоос татгалзах;

2.2.6. Албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудал болон хууль бус үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газар, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлэх;

2.2.7. Албан тушаалын хувьд өөрт захирагдах албан хаагчдад хууль бус аливаа үйлдэл хийхийг даалгах болон шаардахаас татгалзах;

2.2.8. Сонгуулийн дүн мэдээг эрх бүхий этгээд зарлан мэдээлэхээс өмнө аливаа хэлбэрээр нийтэд мэдээлэхгүй байх;

2.2.9. Холбогдох хууль, дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллах.

Гурав. Ёс зүйн зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх

3.1. Хууль тогтоомж болон энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг ёс зүйн зөрчил гэж үзнэ.

3.2. Иргэд, байгууллагаас албан хаагчтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу ёс зүйн асуудал эрхэлсэн Ёс зүйн хороо нь тухайн албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгаж тогтоон дүгнэлт гаргана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Ёс зүйн хороо энэ дүрмийн 3.2-т заасан ёс зүйн зөрчлийн талаарх дүгнэлтийг хариуцлага тооцох эрх бүхий албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

4.2. Ёс зүйн зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан захиргааны шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан ногдуулна.

--- оОо ---